



ТАВАН БОГД КАПИТАЛ
БОЛОМЖОО БОЛНТ БОЛГО

MONTHLY FOCUS



БРОКЕРИЙН ХЭЛТЭС

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

АРИЛЖАА СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

Дөрөвдүгээр сар




АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС /S&P500/

Хураангуй: Өнгөрсөн сард S&P500 индексийн ханш 4,548.7 ам.доллар дээр нээгдэж, дээд ханш 4,597.0 ам.доллар, доод ханш 4,124.6 ам.долларт хүрч эцэстээ 4,142.5 ам.доллар дээр хаагдлаа.

the-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 10:59 UTC+8

SPX 500 Index, 1h, OANDA, O=129.5 H=143.7 L=126.0 C=141.1



Ханшийн хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлөв:

- ✓ 4-р сарын эхээр Tesla, inc. (TSLA:Nasdaq) хувьцаагаар ногдол ашиг тараана гэж мэдэгдсэний дараа 8%-н өсөлт үзүүлсэн байна.
- ✓ АНУ-ын 3-р сарын инфляцын дүн мэдээ гарсан байна. Тус тайланд дурдсанаар 3-р сард инфляц өмнөх оны мөн үеэс 8.5%-ар өсөж 1981 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүржээ. Харин хүнс болон эрчим хүчний үнийг оруулалгүй тооцсон жилийн суурь инфляцын түвшин 0.3%-ар буюу хүлээгдэж байснаас багаар нэмэгдэж 6.5%-д хүрсэн байна.
- ✓ 4-р сарын эхээр АНУ-ын томоохон компаниудын 1-р улирлын санхүүгийн тайлан гарчээ. Тодруулбал үүсээд буй өндөр инфляцын түвшинд томоохон компаниуд хэрхэн дасан зохицож ажилласныг хөрөнгө оруулагчид харахыг хүссэн бөгөөд Fastenal болон Delta Air Lines-ийн дүн мэдээ хүлээгдэж байснаас өндөр гарсан бол Оросын эсрэг хийсэн хориг арга хэмжээтэй холбоотойгоор JPMorgan Chase-н эхний улирлын ашиг 42%-ар буурч хувьцааны үнэ унасан байна.
- ✓ Холбооны Нөөцийн Сангийн бодлогын хүүгийн өсөлт болон зах зээлийн тодорхой бус байдлын нөлөөгөөр АНУ-ын Засгийн Газрын 10-н жилийн хугацаатай бондын өгөөж нэмэгдсэн байна. 4-р сард нийт 26.4%-ын өсөлтийг үзүүлжээ.



S&P 500 ИНДЕКСИЙН ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

4Hour ханшийн график :



✓ Ханш том цагаар өсөлтийн хандлагатай сувагт арилжаалагдаж байгаа бөгөөд сувгийн ёроолын бүс болон дэмжих бүс дээр ирээд байна.

Daily ханшийн график :





БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКС/HSI

Хураангуй: Өнгөрсөн сард HSI индексийн ханш 21,693 хонгконг доллар дээр нээгдэж, дээд ханш 22,523 хонгконг доллар, доод ханш 19,665 хонгконг долларт хүрч эцэстээ 21,089 хонгконг доллар дээр хаагдлаа.

lbc-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 11:04 UTC-8

Hang Seng Index, 30, TVC O21082.75 H21137.93 L21071.27 C21089.40



Ханшийн хөдөлгөөнд дараах хүчин зүйлс нөлөөлөв:

- ✓ БНХАУ-ын Шанхай хотын эрх баригчид 3-р сарын сүүлчээс эхлэн хэсэгчилсэн хөл хорио тогтоогоод байсан бол удалгүй нөхцөл байдал хүндэрч нийтээр нь хөл хорионд оруулсан байна. Шанхай хот нь Хятадын ДНБ-ын 3.8%-ыг дангаараа бүрдүүлдэг юм.
- ✓ Хятадын аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын индекс өнгөрсөн 5-н сарын хугацаанд анх удаа 50-н нэгжээс доош орж 49.5-нэгж дээр ирэв. Энэ нь цар тахлаас шалтгаалж эрэлт буурч буйг илтгэж буй юм.
- ✓ БНХАУ-ын Ерөнхий сайд Li Keqiang Засгийн Газрын долоо хоног бүрийн хуралдаан дээр Хятадын арилжааны банкнуудын заавал байлгах нөөцийн хэмжээг “тохиромжтой цагт нь бууруулна” гэж мэдэгджээ. Гэвч энэхүү мэдэгдлийн дараа Төвбанк тодорхой алхам хийхээс зайлсхийсэн байна.
- ✓ БНХАУ-ын удирдагч Xi Jinping жил бүр болдог Hainan мужийн Boao Forum-д онлайн хэлбэрээр үг хэлсэн байна. Энэ жилийн гол сэдэв нь үйлдвэрлэл, технологийн гол төвүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг царцаагаад буй цар тахалтай тэмцэхэд анхаарах гэж мэдэгджээ. Сарын сүүлээр Хятадын Коммунист намын Улс төрийн товчооны хурал болж эдийн засгийг дэмжихээ амласан байна.



HANG SENG ИНДЕКСИЙН ТЕХНИК ШИНЖИЛГЭЭ

Daily ханшийн график :

tbc-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 09:36 UTC+8

Hang Seng Index, 1D, TVC O:20271.40 H:21176.58 L:20040.07 C:21089.40



TradingView

- ✓ Ханш том цагийн чарт дээр өсөлтийн Pitchfork буюу сэрээн дотор арилжаалагдаж байгаа бөгөөд сэрээний параллель дэмжигч шулуунаас дэмжлэг авсан байна.
- ✓ Жижиг цаг дээр ханш уналтын хандлагатай суваг дотор арилжаалагдаж, сувгийн ёроолоос дэмжлэг авсан байна.

Weekly ханшийн график :

tbc-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 09:35 UTC+8

Hang Seng Index, 1W, TVC O:32284.60 H:31176.58 L:19665.49 C:21089.40



TradingView



АНУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Голлох мэдээллүүд:

- ✓ Геополитик: Орос улс цөмийн дайны эрсдэлийг "бодит" гэж нэрлэж, дайны галыг нэмэгдүүлж байна. Энэ нь эрсдэлтэй хөрөнгөд сайнаар нөлөөлөхгүй буюу "Growth" төрлийн технологийн хувьцаанууд ихээхэн эрсдэлтэй юм. Түүнчлэн ОХУ-ын зүгээс Польш, Болгарт байгалийн хийн нийлүүлэлтээ зогсоохоор болсон байна.
- ✓ Инфляц: Нийлүүлэлтийн гинжин хэлхээний удаан үргэлжилсэн асуудлууд, Хятад улсын "COVID-19" цар тахлаас шалтгаалсан хатуу хөл хорио, Украин дахь дайн зэрэг нь хэрэглэгчид болон бизнес эрхлэгчдийн зардлыг нэмэгдүүлж байна. Энэ бол 1970-аад оноос хойш тохиолдсон хамгийн том түүхий эдийн шокийн нэгд зүй ёсоор орохоор тодорхой бус байдал ихтэй цаг үе юм.
- ✓ АНУ-ын хөрөнгийн захад урт болон дунд хугацаанд уналт ирэх магадлалтай байна.

ОНЦЛОХ ХУВЬЦАА

Tesla (TSLA) - NASDAQ

tbc-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 11:26 UTC+8
Tesla, Inc., 4h, NASDAQ, 0901.42 H905.76 L870.00 C870.18



- ✓ Ханш өсөлтийн хандлагатай арилжаалагдаж байгаа бөгөөд оройн эсэргүүцэх бүсээс уналт үзүүлээд байна.



БНХАУ-ЫН ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

Голлох мэдээллүүд:

- ✓ “Covid-19” цар тахалтай холбоотойгоор Хятадын эдийн засгийн өсөлт зорилтот 5.5%-ын түвшиндээ хүрэхэд саад учраад буй юм. Тэгвэл Олон Улсын Валютын Сангийн зүгээс 2022 онд Хятадын эдийн засгийн өсөлтийн таамаглалыг 4.8%-аас 4.4% болгон бууруулсан байна.
- ✓ Үүсээд буй нөхцөл байдал хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлж Hang Seng индекс 4-р сард нийт 4.1%-аар унасан бол Хятадын Шанхайн нэгдсэн индекс Азийн хамгийн тааруу гүйцэтгэлтэй индекс болсон байна. Улмаар Коммунист намын Улс төрийн товчооны хурлаар татварыг бууруулах, эдийн засгаа дэмжих, бодлогыг түргэтгэх, мөнгөний бодлогын шинэ арга хэрэгсэл ашиглах мөн үр ашигтай хөрөнгө оруулалт хийх зэрэг бодлогын арга хэрэгслүүдийг ашиглахаа амласан байна.

ОНЦЛОХ ХУВЬЦАА

Mongolian Mining Corp (975)- НКЕХ

tbc-tavanbogdcapital published on TradingView.com, May 02, 2022 11:28 UTC+8

MONGOLIAN MINING CORP, 4h, HKEX, O3.30 H3.42 L3.30 C3.39



- ✓ Ханш 2021 оноос хойш 1.7-3.4-ийн хооронд тогтворжилтонд арилжаалагдаж байгаа бөгөөд өсөлт үзүүлж 4.1 дээр байрлах эсэргүүцэх бүсээс эсэргүүцэл авч уналт үзүүлэн тогтворжилтийн бүсрүү буцаж орж ирсэн байна.



ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

БОГД БАНК ХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГАА ТАНИЛЦУУЛЖЭЭ.

Өнөөдөр "Богд банк ХК-ийн 2021 оны аудитлагдсан тайлан болон 2022 оны зорилт" сэдвээр Таван богд капитал ҮЦК ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Мөнх-Эрдэнэ, Богд банкны Гүйцэтгэх захирал Г.Саруул нар Богд банк ХК болон Таван богд капитал ҮЦК FB хуудсаар зэрэг дамжуулж байна. Богд банк нь анх проспектусдаа 2021 онд 9.3 тэрбум төгрөгийн ашиг олохоор төлөвлөж байсан бол бодит гүйцэтгэл 10.2 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөөгөө 10% давуулан биелүүлсэн байна.

ІРО ХИЙСЭН ХК-УУДЫН ХАНШИЙН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ 10.2%

- 2017 оноос хойш анхдагч зах зээл дээр нийт 13 компани IPO хийснээс 9 ХК-ийн нэгж хувьцааны ханш 16%-197% хувь өсөлт үзүүлсэн байна. Анх хувьцаа гаргах үеэс хувьцааны ханш унасан 4 ХК байгаа юм.
- Эдгээр 13 ХК-ийн хувьцаагаар багц бүрдүүлсэн тохиолдолд жилд дунджаар 10.2%-ийн өгөөж хүртэх боломжтой байжээ.
- Ашигт ажиллагаанд хараахан хүрээгүй байгаа CU болон ERDN компаниудыг хасаж, үлдсэн 11 ХК-ийн дундаж үнэ ашгийн харьцааг тооцвол 19.7x байна. Харин сүүлийн 10 жилийн хугацаанд I ангиллын компаниудын үнэ ашгийн дундаж харьцаа нь 18.71x байсан байна.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

“ГОВЬ БОНД”-ИЙН 700 САЯ ТӨГРӨГИЙН АРИЛЖАА ХИЙГДЛЭЭ

- Анхны бүрэн хөрвөх чадвартай Говь бондын 700 сая төгрөгийн хоёрдогч зах зээлийн арилжаа явагдлаа. Ингэснээр бид бондын хөрвөх чадварыг хангах үүргээ цаг хугацаанд нь 100 хувь хангаж ажиллаа.
- Говь бонд нь 2021 оны 12 сард гарсан бөгөөд түүнээс хойш хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 10 гаруй тэрбум төгрөгийн арилжаа хийгдээд байна. Энэ нь биржийн бус зах зээлд бүртгэлтэй бондуудтай харьцуулахад өндөр үзүүлэлт юм.

БАНК РЕФОРМЕР: СИСТЕМИЙН НӨЛӨӨ БҮХИЙ БАНКУУДЫН АШГИЙН МАРЖ 2 ДАХИН НЭМЭГДЖЭЭ

- Системийн нөлөө бүхий 5 банкны дундаж ашгийн марж 2021 онд өмнөх оноос 7.8 нэг хувиар нэмэгдэж, 17%-д хүрчээ. Үнийн дүнгээр илэрхийлвэл 256-с 517 тэрбум төгрөг хүртэл өссөн үзүүлэлттэй байна.
- Банкны хамгийн том зардал нь хүүгийн зардал байдаг ба 2020 онд хүүгийн зардлын хүүгийн орлогод эзлэх хувь 66% байсан бол жилийн дараа 55% болж буурсан байна.
- Банкны салбарын ашигт ажиллагааны өсөлтийн гол шалтгаан нь харилцах, хугацаагүй хадгаламжийн хүү тэглэлт байсан. Мөн бодлогын хүүгийн бууралтын үр дүнд зээлийн хүүгийн бууралтаас илүү хугацаатай хадгаламжийн хүүгийн буурсан нь нөлөөлсөн байна.






ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НОГДОЛ АШГИЙН СУДАЛГАА: АПУ ХК НОГДОЛ АШГИЙН ӨГӨӨЖӨӨР ДАХИН ТЭРГҮЛЛЭЭ.

- Монголын хөрөнгийн биржийн I ангиллын 22 компаниудаас 17 ХК нь 2021 оны цэвэр ашгаасаа нийт 143 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараахаа зарлаад байна.
- Эдгээр компани нь цэвэр ашгаасаа 5%-аас 100% хүртэлх дүнгээр ногдол ашиг болгон зарлаж байгаа нь одоогийн ханшаар тооцвол, хөрөнгө оруулагчдад дунджаар 2.6%-ийн өгөөж хүртээж байна. Үүнээс АПУ ХК нь хамгийн өндөр ногдол ашгийн өгөөжтэй (6.7% 2022 оны 4-р сарын 4-ний ханшаар) байна.
- Ногдол ашгийн өгөөж хувьцааны ханшийн өсөлтийн нөлөөгөөр өмнөх сараас буурсан үзүүлэлттэй байгаа юм.

БАНК РЕФОРМЕР: ХАСБАНКНЫ АУДИТЛАГДСАН ТАЙЛАНГААР 2021 ОНД ЦЭВЭР АШИГ НЬ 2.5 ДАХИН ӨСЖЭЭ

- Хас банкны 2021 оны жилийн эцсийн аудитлагдсан тайлан гарсан ба урьдчилсан тайлантай харьцуулахад цэвэр ашиг 13 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 75 тэрбум төгрөгт хүрсэн байна. Энэ нь 2020 оныхоос 2.5 дахин өссөн үзүүлэлт юм.
- Ингэснээр тус банкны өөрийн хөрөнгийн өгөөж (RoE) нь 21.6% хүрээд байгаа нь хамгийн өндөр ашигт ажиллагаатай Хаанбанкны түвшинтэй зэрэгцэж байна.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

"БАНК ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ КОМПАНИ БОЛОХЫН ДАВУУ ТАЛ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ" СЭДВЭЭР ЯГ ОДОО ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ӨРНӨЖ БАЙНА

- IPO MONGOLIA 2022 FORUM - ХҮРТЭЭМЖТЭЙ ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ арга хэмжээ өнөөдөр зохион байгуулагдаж байгаа билээ. Харин яг одоо "Таван Богд Капитал ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Мөнх-Эрдэнэ "Банк олон нийтэд нээлттэй компани болохын давуу тал, хөрөнгийн зах зээлд үзүүлэх нөлөө" сэдвээр чиглүүлэгч хийн хэлэлцүүлэг өрнүүлж байна.

ӨНӨӨДӨР БИРЖИД: ИНВЕСКОР ББСБ ҮНИЙН ДҮНГЭЭР ТЭРГҮҮЛЭВ

- 2022 оны 4-р сарын 14-ний байдлаар I ангилалд 17 компанийн нийт 374,426 ширхэг хувьцаа 473,766,376 төгрөгөөр, II ангилалд 10 компанийн нийт 123,383 ширхэг хувьцаа 91,985,453 төгрөгөөр, III ангилалд 8 компанийн нийт 91,185 ширхэг хувьцаа 231,474,352 төгрөгөөр арилжаалагджээ.
- Арилжааны үр дүнд ханш нь өссөн 5 хувьцаа нь Дархан Хөвөн, Талх Чихэр, Тэнгэрлиг Медиа Групп, Монгол Нэхий болон Монгол Базаальт гэсэн компаниуд байсан ба өсөлт нь 9.9%-аас 14.7%-ийн хооронд хэлбэлзсэн үзүүлэлттэй байна.
- Девелопмент Корпорэйшн нар байжээ.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

МХБ ДЭХ ТОП ДААТГАЛЫН ХК-УУДЫН АЛЬ НЬ ЮУГААРАА ИЛҮҮ ВЭ?

- Мандал Даатгал компанийн хувьцааны ханш нь жилийн дундаж өсөлтөөр (21%) болон хөрвөх чадвараар ялгарчээ.
- Ард Даатгал нь Мандал, Бодь даатгалтай харьцуулахад хямдхан харагдаж байгаа ч 2022 оны гүйцэтгэл ямар байх нь бидний хамгийн гол анхаарах үзүүлэлт юм.
- Бодь Даатгал нь нийт хураамжийн орлого, нөхөн төлбөрөөр тэргүүлж байгаа ба мөн хохирлын болон хосолсон харьцаа нь салбарын дунджаас дээгүүр гарсан ажээ.

БАНК РЕФОРМЕР #5 | УЛИРЛЫН БАЙДЛААР ХАСБАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ ОРГИЛ ЦЭГТЭЭ ХҮРЛЭЭ

- ХасБанкны 2022 оны эхний улирлын тайлангаар цэвэр ашиг нь жилийн 81%-аар өсөж ₮23 тэрбум гарсан ба өөрийн хөрөнгийн өгөөж 24.6%-д хүрсэн байна.
- Энэхүү ашигт ажиллагааны өсөлтөд хүүгийн зардал 26%-аар буурсан нь голчлон нөлөөлжээ.
- Балансын хувьд цэвэр зээл 40%, харилцах, хадгаламж 12%, нийт хөрөнгө 7% харин өөрийн хөрөнгө 41%-аар тус тус өссөн үзүүлэлттэй байна.





ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

БАНК РЕФОРМЕР: I УЛИРАЛД ГОЛОМТ БАНКНЫ АШИГ 8 ДАХИН ӨСӨЖ, ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ 6.9%-Д ХҮРЛЭЭ

- Голомт банкны 2022 оны эхний улиралд цэвэр ашиг нь өмнөх оны мөн үеэс 8.8х дахин өсөж, ₮22.8 тэрбум гарсан ба өөрийн хөрөнгийн өгөөж 6.9%-тай байна. (RoаE: сүүлийн 12 сарын ашиг болон дундаж өөрийн хөрөнгөөр тооцов)
- Энэхүү ашигт ажиллагааны өсөлтөд хүүгийн орлогын тогтвортой түвшинд хүүгийн зардал 26%-аар буурсан нь голчлон нөлөөлжээ.

ӨНӨӨДӨР БИРЖИД: ХУВЬЦААНЫ ӨӨРЧЛӨЛТ

- Өнөөдрийн арилжаагаар үнийн дүнгээр ялгарсан компани нь Сэнтрал Экспресс Си Ви Эс болж тодорлоо. Тус компанийн хувьцааны ханш өдрийн арилжаагаар өмнөх өдрийн хаалтын ханшаас 0.25% буурч, 209.35 төгрөг болж өөрчлөгджээ. Өнөөдрийн арилжааны үнийн дүн 27.66 сая байсан ба хувьцааны өдрийн дундаж арилжаа болох 25.76 сая төгрөгийг давсан дүнгээр арилжаа хийгдсэн тул ханшид бага хэмжээний өөрчлөлт орсон байна.
- Тус сарын арилжааны үр дүнд Ард Санхүүгийн Нэгдэл, Сэнтрал Экспресс Си Ви Эс, АПУ, Түмэн Шувуут болон Эрдэнэ Ресурс идэвхтэй арилжаалагдсан байдалтай байна.





ТАВАН БОГД КАПИТАЛ

БОЛОМЖОО БОДИТ БОЛГО



БРОКЕРИЙН ХЭЛТЭС

АНДЕРРАЙТЕРИЙН ХЭЛТЭС

АРИЛЖАА СУДАЛГААНЫ ХЭЛТЭС